



SHARYN GOL jsc

“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 02 сарын 16 едөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 46.1, компанийн дүрмийн 12 дугаар бүлгийн заалт, ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2014 оны бизнес төлөвлөгөөгөөр 1,200.0 мянган тонн олборлож 1,120.0 мянган тонн нүүрс борлуулахаас 749,7 мянган тонн олборлож, 707,3 мянган тонн нүүрс борлуулан нүүрс олборлолтын төлөвлөгөө 62,5 хувь, нүүрс борлуулалтын төлөвлөгөө 63,2 хувийн биелэлттэй байсан.
Нийт хөрс хуулалтын төлөвлөгөө 5,560.0 мянган шоо метр, гүйцэтгэл нь 7,729.9 мянган шоо метр буюу 139,0 хувийн гүйцэтгэлтэй, төлөвлөсөн хэмжээнээс 2,169.9 мянган шоо метрээр илүү хуулан зардал ихэссэнээс үйлдвэрлэлийн ашиг алдагдалд нөлөөлж 3,616.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.
Тайлант онд 4,047.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, нүүрс баяжуулах үйлдвэрийн угсралтын ажилд 3,046.2 сая төгрөг зарцуулсан зэргээс шалтгаалан 2014 оны жилийн ажлын үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.
 2. Энэхүү тогтоол, түүнтэй холбогдсон шалтгаан, тооцоолол бүхий тайлбарыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг компанийн гүйцэтгэх захирал /Б.Батбаатар/-д даалгасугай.

ЛАРГА

Б.БАТМОНХ



**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2015.4.30

№ 01

Улаанбаатар

“Шарын гол”ХК-ий хувьцаа эзэмшигчдийн хурал 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 16¹⁰ цагт “Корпорейт зочид буудал” ХХК-ийн хурлын танхимд эхэлж 18²⁰ цагт дуусав.

Хурлын эхэнд компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбогдсон хийгдэх ажил, цаг хугацааны графикчилсан төлөвлөгөөний гүйцэтгэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Батсуурь танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирсэн саналын хуудсаар хуралд оролцогчдын ирцийг тооллогын комисс /Л.Эрхбаатар/ нэгтгэн гаргалаа.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд нийт 10.231.389 ширхэг энгийн хувьцаанаас 10.170.242 ширхэг саналын эрхтэй хувьцааг төлөөлж 9.532.144 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч буюу 93,7 хувь нь хуралд ирсэн учир хурлын ирцийг хангалттай гэж үзэж байгаа гээд уг хуралд санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан тайлбар өгөн, тооллогын комиссын мэдээллийг тооллогын комиссын дарга Л.Эрхбаатар уншиж сонсгоод хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье гэв.

Хурлыг нээж, хурлын дарга Б.Батмөнх үг хэлж, хуралд хэлэлцэх асуудал, хурлын дотоод дэгийг танилцуулав.

... 5. **ХЭЛЭЛЦСЭН НЬ:** “Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах”

Б.Батмөнх – Энэ асуудлаар санал хураахгүй, зөвхөн танилцуулах тул ТУЗ-ийн шийдвэр бүхий тогтоолыг эдийн засагч Л.Оюундарь танилцуулж тайлбар хийнэ гэв.

Л.Оюундарь – Өнгөрсөн жил уулын ажлын хүндэр нийлээд байсан тул хөрс хуулалтыг ахиу явуулснаар нүүрс олборлолт төлөвлөсөн хэмжээндээ хүрээгүй.

Мөн топог тохооромжийн шинцчлэл болох нүүрс баяжуулах үйлдвэр, Пако түлшний үйлдвэрт нийлээд хэмжээний хоропго оруулалт хийгдсэн. Шинээр машин техник төлөвлөгдсөн хэмжээнд авах шаардлагатай байсан зэргээс бид 3,6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан гэдгийг өмнөх тайландаа дэлгэрэнгүй танилцуулсан.